

УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК

2024 оны 03 дугаар
сарын 11 -ны өдөр

№: 24/06

Улаанбаатар
хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59, 60, 62, 64, 65, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

- Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 09:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө хаягт байрлах "Номин юнайтед" төвд биечлэн болон цахим хэлбэрээр хослуулан зохион байгуулахаар тогтоосугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг батлах.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
- Компани нь сүүлжийн жилүүдэд бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй тул Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2023 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэснийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
- Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр хурлын зарыг нийтэд эхэлж хүргэхээр тогтоосугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр, 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрүүдэд өдөр тутмын сонин хэвлэл болон телевиз, радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэхээр тогтоосугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөр тасалбар болгосугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг брокер дилерийн компаниудад 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор дамжуулан тараахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн болон цахим хэлбэрээр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөр тасалбар болгож, брокер дилерийн компани болон Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн

- өргөн чөлөө-67/1 тоот хаягт байрлах “Номин юнайтед” цогцолборын 5-р давхарт тус тус хүлээж авахаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Я.Навааныг томилсугай.
 10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Эдийн засагч Ганзоригийн Өсөхбаярыг, тооллогын комиссын гишүүдээр Хуульч Галбадрахын Мягмартуяа, Нягтлан бодогч Нямбаатарын Сүрэнжав нарыг томилсугай.
 11. Хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар, гишүүдээр ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарыг томилсугай.
 12. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН